



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 25 өдөр

Дугаар А/54

Шивээговь сум

Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын
улсын үзлэг явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Автотээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.5, аймгийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн А/72 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын улсын үзлэг, оношилгоог 2022 оны 04 дүгээр сарын 26-ны өдрөөс 04 дүгээр сарын 29-ний өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Сумын нутаг дэвсгэрт тээврийн хэрэгслийн техникийн хяналтын улсын үзлэг, оношилгоог явуулах ажлыг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:

Ч.Сугармаа

(Засаг даргын орлогч)

Гишүүд:

Д.Сувд-Эрдэнэ

(1 дүгээр багийн Засаг дарга)

С.Отгонбаатар

(2 дугаар багийн Засаг дарга)

Ё.Батцэнгэл

(Шивээ-Овоо хувьцаат компанийн Тээвэр үйлчилгээний хэсгийн механик)

Нарийн бичгийн дарга:

Г.Ууганбаатар

(Цагдаагийн хэсгийн жижүүрийн цагдаа, ахлагч)

3. Сумын төвийн албан байгууллага, аж ахуйн нэгж, 1, 2 дугаар багийн иргэдийг хуваарийн дагуу автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг оношилгоонд хамруулж, зохион байгуулж ажиллахыг комиссын дарга (Ч.Сугармаа)-д үүрэг болгосугай.

4. Өөрийн багийн болон байгууллагын эзэмшил, харьяаллын тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангаж хуваарийн дагуу тооллогод хамруулахыг 1, 2 дугаар багийн Засаг дарга, албан байгууллага, аж ахуйн нэгжүүдийн дарга, захирал, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ